



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/49

Мандалговь

“Био Медикал Инженеринг” ХХК-тай гэрээ  
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/16 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Мал эмнэлгийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Био Медикал Инженеринг” ХХК-тай 42,700,000 (дөчин хоёр сая долоон зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу Мал эмнэлгийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Био Медикал Инженеринг” ХХК-ны гүйцэтгэх захирал (Б.Чинзориг)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



П. ДОРЖБАТ

486210235